

“МНТ”-НЫ Э.ХЕНИШИЙН ГЕРМАН ОРЧУУЛГЫН ОЙРОЛЦОО УТГАТ ҮЙЛ ҮГИЙН ДҮЙЦЭЛ

/“Амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийн жишээ/

Г.Эрдэнэнаран²³

Товч утга: МНТ-ны Э.Хенишийн герман орчуулгын ойролцоо үгийн дүйцлийг харьцуулан нягтлахын тулд “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийн утгын болон найруулгын ялгамжийг тодруулж улмаар эдгээр ялгааг орчуулгад хэрхэн буулгасныг харуулахыг зорилоо.

Түлхүүр үг: ойролцоо утгат үг, хэллэг; орчуулгын дүйцэл; уран зохиолын орчуулга

МНТ судлалын түүхэн замналыг сөхвөл гадаад, дотоодын монголч эрдэмтэд ихэвчлэн уг зохиолын монгол үг хэллэгийг хятад үсгээр галигласан эх, түүний хятад орчуулгад анхаарлаа хандуулан уг сурвалж бичгийг шинжлэх ухааны олон өнцгөөс судалж, харьцуулж, мөн орчуулж ирсэн бол сүүлийн жилүүдэд судалгааны чиг хандлага нь өөрчлөгдөж МНТ-ны анхны монгол бичгийн эхийг сэргээх, орчин цагийн монгол хэлнээ хөрвүүлэх, монгол түүхэн сурвалжуудтай харьцуулан утгын тайлбарыг хийх зэрэг ажлуудыг түлхүү хийх болсон байна. Энэ нь МНТ-ны уламжлагдан ирсэн нангиад эх, эхүүдийн хувилбар болон түүний хадмал орчуулга, галиг зэрэгт тухайлбал, авианы үсэг биш хятад үсгээр монгол хэлний үсгийн авиаг буулгахад, түүнчлэн сонгодог бичгийн өмнөх үеийн бичгийн дурсгалын онцлогоос улбаалж буруу бичигдсэн, орхидуулсан, давхардуулсан зэрэг зүйл цөөнгүй байдагтай²⁴ холбоотой юм.

Эдүгээ МНТ-ны 24 монгол хөрвүүлэг байгаагаас эл судалгааны ажилд Ш.Чоймаагийн (2011) “МНТ, эртний үг хэллэгийн тайлбартай шинэ хөрвүүлэг”-ийг Э.Хенишийн герман орчуулгатай харьцуулан судаллаа.

	Огноо	Нэр	Гарчиг буюу онцлог
1.	1917 он	гүн Бавуудайн Цэнд	Юан улсын нууц түүх
2.	1939 он	Широ Хаттори	Монгол үсгийн МНТ
3.	1941 он	Ү.Бөххишиг	Монголын нууц тууж
4.	1941 он	Б.Хишигбат	Юан улсын нууц товчоо
5.	1941 он	Алтан-Очир	МНТ
6.	1947 он	Ц. Дамдинсүрэн	МНТ

²³ МУИС, ШУС, Европ судлалын тэнхим, докторант

²⁴ Ш. Озова: 1980. Орчуулсан 2002, Б.Баярмэнд

7.	1957 он	Ц. Дамдинсүрэн	МНТ
8.	1973 он	Баяр	МНТ
9.	1984 он	Х.Дугаржав	МНТ-ны харгуулан хянасан дэвтэр
10.	1985 он	Мансан	Шинэ орчуулж тайлбарласан МНТ
11.	1986 он	Ц. Элдэнтэй, Э.Ардаажав	МНТ
12.	1987 он	М. Иринчин	МНТ
13.	1987 он	Х. Дорба	МНТ, ойрад аялгууны бичгийн хэлээр
14.	1990 он	Ш.Гаадамба	МНТ, худам монгол бичгээр сийрүүлсэн
15.	1990 он	Д.Цэрэнсодном	МНТ, орчуулга 1993 он монгол бичгээр хэвлүүлсэн, 2000 он дахин хэвлэлт
16.	1990 он	Б.Сумьяабаатар	МНТ , үсгийн галиг
17.	2002 он	А.Шонхор	МНТ, латин галиг уйгаржин үсгийн сэргээлт
18.	2005 он	А.Цанжид, д.Цэрэнсодном	монгол бичиг, кирил үсгийн сонгомол эх
19.	2005 он	Чой Г Хү, Б.Сумьяабаатар	монгол үсгийн анхны галиг
20.	2006 он	Ш.Чоймаа	Монголыг түүхэн сурвалж бичгийн цуврал бүтээлийн тэргүүн боть МНТ үг хэллэг, утгын тайлбар
21.	2006 он	Д.Пүрэвжав	МНТ, шинэ орчуулга
22.	2006 он	Эрдэмт	МНТ, одоо үеийн монгол хэлний аялгууунд
23.	2008 он	Э.Ардаажав	МНТ
24.	2011	Ш.Чоймаа	МНТ, эртний үг, хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг.

Хүснэгт 1: Эх сурвалж. Э. Пүрэвжав. 2010 он

МНТ-ны нийт 5 герман орчуулга хэвлэгдэн гарсан. Тэдгээрээс анхны орчуулгыг 1941 онд Э.Хениш хийж, 1948 онд дахин хэвлүүлсэн. Хоёр дахь орчуулгыг 1989 онд М.Таубе туурвисан бөгөөд 2006 онд уг орчуулгын хоёр дахь хэвлэлт олон нийтийн хүртээл болсон. Харин 1981 оны В. Хайсигийн эрхлэн гаргасан “Монголчуудын нууц товчоо, Түүх бичсэн туульс”-д МНТ-ны Э.Хенишийн орчуулгыг “Жангар” болон “Хан Харанхуй” туужийн хамтаар эмхэтгэн оруулжээ.

Энд МНТ-ны анхны герман орчуулга буюу Э.Хенишийн 1941 оны орчуулгын дүйцлийг “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийн жишээгээр харгуулан тайлбарляа.

МНТ-ны үйл үгийг Д. Бадамдоржийн (2001) монгол хэлний үгийн сангийн утгазүйн хөдөлгөөнт утгын орны биеэр, хэлээр, сэтгэлээр үйлдэх үйл үгийн ангиллын

онолд тулгуурлан түүвэрлэхэд нийт давтагдсан тоогоор 4316 биеэр, 1150 хэлээр, 203 сэтгэлээр үйлдэх үйл үг байна.

МНТ –ны бүлэг	Биер үйлдэх үйл үг	Хэлээр үйлдэх үйл үг	Сэтгэлээр үйлдэх үйл үг
1	306	75	12
2	425	127	20
3	316	103	15
4	391	86	20
5	410	122	22
6	423	102	14
7	364	116	4
8	317	52	15
9	297	84	20
10	251	83	15
11	369	77	23
12	447	123	23
Үйл үгийн тоо	4316	1150	203

Хүснэгт 2. МНТ-ны үйл үгийн түүвэр /Ш.Чоймаа/.

МНТ зохиолын гол агуулгад эзэнт гүрний үүсэл хөгжил, Чингис хааны байлдан дагуулалт зэрэг түүхэн үйл явдал зэргийг өгүүлсэн тул биеэр үйлдэх үйл үг нийт үйл үгийн 76%-ийг эзэлж байгаа нь хэл найруулгын хувьд хүүрнэх болон тоочин бичсэн зүйл цөөнгүй байдагтай холбоотой юм. Гэхдээ МНТ-ны хэл найруулга нь уран зохиолын дүрслэн илэрхийлэх арга хэрэглүүрийг өргөн ашиглаж “яруу төгс”²⁵ өнгө аястай байдаг билээ. Тиймээс ч МНТ-д ойролцоо үг, эсрэг үг, төсөөтэй үгийг сүүл, толгой холбох зэргээр үгсийн сангийн бүхий л нөөцийг хэрэглэснээр зохиолын найруулга нь яруу сонголт болжээ. Эдгээрээс “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийг дэлгэрэнгүй авч үзье.

Монгол хэлний ойролцоо утгыг эрдэмтэн судлаачид хэл бичиг, хэлшинжлэл болон утга зохиол шинжлэлийн талаас судалж цөөнгүй бүтээл туурвисан байна. Тэдгээрийг ерөнхийд нь тоймлоход, бусад хэл шинжлэлийн судалгаануудын адил хэлний нэгжийн талаархи буюу ойролцоо утга гэж нэгдсэн нэг нэр томъёонд хараахан хүрээгүй байгаагаас гадна утгын болон бүтцийн ангилал нь өөр өөр байна. Энэхүү өгүүллийн хүрээнд дээрх онолын олон янз, давуу болон сул тал зэргийг дурдалгүй, хамгийн тохиромжтой буюу хамгийн нийтлэг гэсэн онолын дүгнэлтүүдийг тулгуур болгон хэрэглэсэн болно. Тухайлбал, “амьгүй болох” ойролцоо утгат үг, хэллэгийг үгийн сангийн утгазүйн тогтолцооны хүрээнд задлан шинжиллээ.

Дийлэнх судлаачид ойролцоо үг гэж дуудлага нь харилцан өөр боловч утга нь хоорондоо ижил буюу төстэй байна гэдэгтэй санал нэгддэг. Ийм үгсийг ойролцоо нэр

²⁵Ш.Чоймаа, Д.Заяабаатар. Академич Ц.Дамдинсрэнгийн “МНТ”-ы орчуулгын онцлог.

буюу синоним гэнэ²⁶. Ойролцоо нэр зөвхөн хос хосоороо байх төдийгүй хэд хэдэн үгс хоорондоо утга ойролцоо байх ба холбоо үгээр илэрч болно гэдгийн синоним нэр томъёог бусад гадаад хэлний шинжлэлд хүлээн зөвшөөрөгдсөн гэдэг утгаар нь энд хэрэглэлээ. Түүнчлэн ойролцоо утгат үгсийн айн чанар нь утгын ойролцоо, төстэй харьцаанд орших ба хэлний янз бүрийн нэгжүүд утгын шинжээрээ бүрдүүлэгчээр ордог бөгөөд орлох болон нарийвчлах гэсэн утгазүйн үүрэгтэй²⁷ гэдгээс үг-үгийн, үг-нийлэмж үгийн, үг-өвөрмөц хэлцийн, үг-хэвшмэл хэлцийн ойролцоо утгын харьцаанд нь судаллаа.

МНТ-д үйл үгийн давтамжаараа “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэг 70 удаа орсон бөгөөд үүнийг 18 хувилбараар хэлсэн байна.

	“амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэг	Давтамж
1.	Үгүй болох	8
2.	Үхэх	42
3.	нөгчих	1
4.	Хэр дуусах	1
5.	Тэргүүндээ хүртэх болов	1
6.	Хохимойдоо хүртэх болов	1
7.	Аминдаа хүртэх	1
8.	Өндөрт гарваас	1
9.	Хаданд гарваас	1
10.	Цагаанаа цацваас	1
11.	Хард хахваас	1
12.	мөнхрүүлэдхүн	2
13.	Нүгэл мэт бие нэхэс одвоос	2
14.	Тул мэт бие тулбас одвоос	2
15.	Мөнх үгүй	1
16.	Урьдсыг үл удаарах	1
17.	Тэнгэрт гарах	2
18.	Зөв эс болох ёсон	1
Нийт үг, хэллэг		70

Хүснэгт 3. МНТ-ны “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийн хувилбар

1. “Үхэх” гэдэг үг нь амьд биеийн амь тасрах, амьгүй болох гэсэн үндсэн утгатай (МХИТТ)
2. “Үгүй болов” гэдэг а. байхгүй болох, алга болох; б. [шилжсэн] Үрэн таран болох в. [цээр] нас барах үхэх үгийн цээр үг (МХИТТ) бөгөөд байгалийн жам хуулиар хүмүүсийн хөгширч нас нөгчөхийг цээрлэн хэлсэн хэмээн А.Пунсаг (2010:77) үзсэн.
3. “Нөгчих” гэдгийг нас барах (МХИТТ) буюу А.Пунсаг (2010:77) баатар буюу сэцэн цолтой хүмүүсийн “үхэлийг” цээрлэн хүндэтгэлийн утга санааг илтгэж

²⁶Ц.Өлзийхутаг. Монгол хэлний үгийн сангийн судлал. 1979 он

²⁷Д.Бадамдорж. Монгол хэлний утгазүйн шинжилгээ. 2007, х 24

хэрэглэсэн цээр үг гэж тогтоосон. Энэ нь сэцэн цолтой хүмүүсийн зуурдаар буюу зол бусаар нас эцэслэсэн гэдгийг илэрхийлсэн утга бүхий цээр үг юм. Түүнээс гадна “нөгчив” хэмээх үгийг “өнгөрөн явав” гэсэн утгаар бас МНТ-д хэрэглэсэн байна гэдгийг Ш.Чоймаа (2011) болон А.Пунсаг (2010) нар үзсэн. Тухайлбал МНТ-ны 2:82-т Тэмүжин тайчуудаас дөнгөтэйгээ оргон зугтах үед Сорхон Шар түүнийг үзэвч өнгөрөн явахыг ийн өгүүлжээ: Харигт хэвтэж бүхүйг Сүлдүсийн Сорхон Шар зөв дайрч үзэж өгүүлрүүн: Зөв л. Ийм аргатын тул “нүдэндээ галт, нүүртээн гэрэт” хэмээн Тайчууд ах дүүдээн тийн л найтагдан ажгуу, чи. Тийнхүү хэвт. Үл заах, би” хэмээгээд нөгчив гэхэд үл заах би гээд өнгөрөн явав гэсэн утгатай байна. Мөн МНТ-ны 4:145-т Чингис хаан шархдан хэвтэж байх үед: Зэлмэ бус хүмүүнийг үл итгэн, сахиж сууж, шөнө дөл болтол бөгөлсөн цусыг амаар дүүрэн залгиад асгаад, шөнө дүл нөгчвөөс гэхэд мөн шөнийг өнгөрөөв гэсэн утгатай байна.

4. “Хэр дуусах” гэдгийг (МХИТТ)–д дөрөв дэх салаа утга буюу өнгөрөх, нас барах, үхэх, үрэгдэх, үгүй болох гэсэн бөгөөд Ш.Чоймаа (2011) үхэж дуусах буюу амьд хүмүүн байваас хэрхэн төгсөх гэж “үхэх” гэдэг утгын бас нэг хувилбар гэж хөрвүүлсэн.
5. “Тэргүүндээ хүртэх болов” болон 6-д буй “Хохимой тэргүүндээн хүртэх болов” нь толгойд нь хүрэх (МХИТТ) амь насыг нь хөнөөх буюу толгойд хүрэх гэдгийг алахын нэг хувилбар бөгөөд “хүрэх” үйлд өртөгчийн урвуу харьцаанд алуулах буюу үхэх гэсэн утгыг илэрхийлж байна гэж үзлээ. Мөн Ш.Чоймаа (2011) хар толгойгоо алдахад хүрэх буюу үхэхэд хүрэх гэж хөрвүүлсэн. Энд хар тэргүүн болон хохимой тэргүүн гэж ойролцоо утгат үгээр орлуулан найруулан бичсэн байна.
7. “Аминдаа хүртэв” гэдгийг Ш.Чоймаа (2011:84) амиа алдахад хүрэх, үхэх гэсэн утгатай буюу уг зохиолд хэмээгээд үхэж одов гэснийг амь алдах нь (МХИТТ) нас барах гэсэн утгатай байна.
8. “Өндөрт гарваас” болон 9-д буй “Хаданд гарваас” гэдгийг “хадан гэртээ морилох” өвөрмөц хэлцийн нэг хувилбар гэж үзээд энэ нь (МХИТТ) нас барахыг цээрлэсэн хэллэг юм. Мөн А.Пунсаг (2010:79) “үхэхийг” цээрлэн хэлсэн хэвшмэл хэллэг гэж тайлбарласан. Энэ нь настай хүмүүсийн өөрийн үхлийг эерүүлэн илтгэсэн хэвшмэл хэллэг хэмээжээ. Харин Ш.Чоймаа (2011) эдгээрийг “үхэхийг” илэрхийлсэн бие даасан хэллэгүүд гэж үзсэн. Тухайлбал, “өндөрт гарваас” гэдгийг Ш.Чоймаа (2011:106) “тэнгэрт халих” утгатай, “хаданд гарваас” гэдэг нь “хадан гэртээ очих” гэсэн утгатай “үхэхийг” хэлсэн хэллэгүүд гэжээ. Энэхүү хэллэгийн ерөнхий утга нь нас нөгчигсдийг өндөр хаданд, асга хаданд оршуулдаг байсан эртний заншилтай холбоотой юм.
10. “Цагаанд цацваас” болон 11-д буй “Хард хахваас” гэдгийн шилжсэн утгаараа (МХИТТ) идсэн уусан зүйл мөгөөрсөн хоолойгоор орж хахан ханиалгах буюу “хахаж үхэх” гэсэн шилжсэн утгатай гэж бид үзэж байна.
12. “Мөнхрүүлэхүн” буюу мөхрүүлэх+дэх нь мөнхрөх үйл үгийн үйлдүүлэх хэв бөгөөд Норжингийн “Монгол хэлний толь”-д үүрдийн болгох гэсэн утгаас нь шилжсэн утгаараа “үхүүлэх” хэмээн эерүүлэн хэлсэн гэж үзэж байна.

13. “Нүгэл мэт бие чину нэхэс одвоос” болон 14-д буй “Тул мэт бие чину тулбас одвоос” гэдгийг “одох” үйл үг нь шилжсэн утгаараа алс хол явах буюу “амьгүй болох” -ийг хэлсэн гэж үзэж байна.
15. “Мөнх үгүй” гэдгийг мөнх бусыг үзүүлэх гэдгийн адил утгаар (МХИТТ) нас барсныг цээрлэн хэлэх гэсэн утгатай.
16. “Урьдасыг үл удаарахуй” гэдгийн “удаарах” үйл үгийн үндсэн утга нь дараалах, дэслэх, удаа дараагаар болох гэдгээс өвөг дээдсийг дагах гэсэн шилжсэн утгаар мөн “амьгүй болох” гэсэн утгын ойролцоо утга гэж үзэж байна.
17. “Тэнгэрт гарав” хэмээн гагцхүү эзэн Чингис хааны нас нөгчихийг цээрлэн хэлсэн. Ингэж хэлэх нь Чингис хааны тэнгэр язгууртай тэнгэрийн хөвүүн хэмээн үздэг ойлголттой холбогдон тэнгэртээ буцсан гэх утгаар хүндэтгэн хэрэглэсэн цээрийн үг гэж А.Пунсаг (2010:78) хэлжээ. 12-р зуунаас хойшхи түүхэн сурвалжид мөн адил Чингис хааны нас барсныг Лувсанданзаны “Алтан товч”-д “тэнгэр болов”, хураангуй “Алтан товч” –д “тэнгэрт халив”, Саган сэцэний “Эрдний товч” –д “Тэнгэр эцэгтээ өөд болон одвой” зэргээр хэлсэн.
18. “Зөв эс болсон” хэмээн хаан хөвгүүдийн “үхэхийг” цээрлэн ингэж хэлдэг гэж А.Пунсаг (2010:79) үзсэн. Гэхдээ энэхүү үхэл нь зүй бусын зуурдын үхэл буюу хорлогдон нас барахыг заасан утга гэж тайлбарласан байна. Түүнчлэн эс болох буюу эс байх гэдэг утгаараа байхгүй болох гэдгийг (МХИТТ) нас барах гэсэн утгатай тул жам бусаар үхсэн гэсэн шилжсэн утгатай гэж үзэж байна.

Эдгээр МНТ-оос түүвэрлэсэн “амьгүй болох” ойролцоо утгат үг, хэллэгийг Д.Бадамдоржийн (2001) үгийн сангийн нэгжийн харьцаанд оруулвал дараах бүтэц бүрүүлдэхүүнтэй болж байна:

№	“амьгүй болох” гэсэн утгалбарын хувилбар	Үгийн сан-утга судлалын нэгжийн харьцаанд Үглэвэр, утгалбарын тоо	Үгийн сангийн нэгжийн хувьд
1	Үхэх	Нэг үглэвэр нэг утгалбар	Үг
2	Үгүй болох	Хоёр үглэвэр нэг утгалбар	Нийлэмж үг
3	Нөгчих	Нэг үглэвэр нэг утгалбар	Үг
4	Хэр дуусах	Хоёр үглэвэр нэг утгалбар	Нийлэмж үг
5	Тэргүүндээ хүртэх болов	Гурван үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
6	Хохимойдоо хүртэх болов	Гурван үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
7	Аминдаа хүртэв	Хоёр үглэвэр нэг утгалбар	Нийлмэл үг
8	Өндөрт гарваас	Хоёр үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
9	Хаданд гарваас	Хоёр үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
10	Цагаанд цацваас	Хоёр үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
11	Хард хахваас	Хоёр үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
12	Мөнхрүүлдэхүй	Нэг үглэвэр нэг утгалбар	Үг
13	Нүгэл мэт бие чину нэхэс одвоос	Зургаан үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
14	Тул мэт бие чину тулбас одвоос	Зургаан үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
15	Мөнх үгүй	Хоёр үглэвэр нэг утгалбар	Нийлэмж үг

16	Урьдасыг үл удаарахуй	Гурван үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц
17	Тэнгэрт гарах	Хоёр үглэвэр нэг утгалбар	Нийлэмж үг
18	Зөв эс болсон ёс тэр	Таван үглэвэр нэг утгалбар	Өвөрмөц хэлц

Хүснэгт 4. МНТ-ны “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийн бүтэц бүрдүүлбэр

Эдгээр 18 ойролцоо утгат үг, хэллэг нь “амьгүй болох” гэсэн нэг утгалбартай, харин үглэврийн олон буюу нэг, хоёр, гурав болон таван хувилбараар үгийн сангийн нэгжийн түвшинд үг, нийлэмж үг, өвөрмөц хэлц зэргээр илэрч байна. Ойролцоо утгын харьцаанд үгийн дотоод агуулга тал тогтвортой байж харин энэ тогтвортой утгыг илэрхийлж чадах гадаад хэлбэр буюу үглэвэр хувилбартай байдаг²⁸. Эдгээр 18 ерөнхий нэг утгатай, хэлбэрийн хувьд өөр өөр бүрдүүлбэртэй ойролцоо утгат үг, хэллэг нь МНТ-ны “амьгүй болох” буюу үхэх гэсэн цөм утгат үг, хэллэгийн утгын цувааг бүрдүүлж байна. Утгын цувааны гишүүн тус бүрийн утгын болон найруулгын ялгааг ойролцоо утгат үгийн бүтцийн утгын задаргаагаар тодорхойлох боломжтой юм. Тухайлбал, Б.Одгэрэл (2010) үгийн сангийн тогтолцооны нэрлэх утгын харьцааны хүрээнд үгийн эсрэгцлээр монгол хэлний “хүний амь тасрах” гэсэн утга бүхий 252 үг, хэллэг ойролцоо утгын цувааг бүрдүүлж байгааг тогтоосон нь анхаарал татсан бөгөөд Н.Нансалмаагийн (2005) уг задаргааны суурь онолд тулгуурлан энд МНТ-ны “амьгүй болох” цөм утгат ойролцоо 18 үг, хэллэгийн утгын болон найруулгын ялгамжийг тодруулахаар оролдлоо.

“Амьгүй болох” гэсэн ерөнхий буюу цөм утгат ойролцоо үг, хэллэг нь утгын эсрэгцлэлээр аль үг, хэллэгтэй ижил байх, багтах, огтолцох харьцаанд орж байгаагаар утгын ялгааг харуулж болно.

Ижил байх харьцаанд үнэмлэхүй ойролцоо утгатай нэрүүд байж болох бөгөөд үгийн утга ижил байх буюу тайлбар толь бичигт харилцан бие биенээ тодорхойлсон байдаг²⁹ гэдгийг үндэс болгон “үхэх”, “үгүй болох” гэсэн хоёр үйл үг мөн “зөв эс болсон” зэрэг МХИТТ -ийн “амьгүй болох, хүнийг бол нас барах” утгаар нь АБ-АБ гэж томъёолж утгын давхцал байна гэж үзэж байна.

Үгийн утгын эсрэгцлэлээр ойролцоо үгийн багтах харьцаанд тухайн нэг үгийн утганцар нөгөөдөө багтахаас гадна, нөгөөд байхгүй, түүнээс ялгарах бүрдүүлбэртэй байна³⁰ гэдгийг харгалзаж “нөгчих” үйл үг нь “амьгүй болох, нас барах” гэсэн утгын АБ-АБ давхцалаас гадна, АБ-АБ+В баатар буюу сэцэн цолтой хүмүүсийн “үхэлийг” цээрлэн хүндэтгэлийн утгаараа ялгаатай, “мөнх үгүй” гэж шилжсэн утгаар аливаа юманд эцэс, төгсгөл байдаг бөгөөд тэр нь үхэл буюу хүн үхэх л болно гэдгийг цээрлэн хэлсэн гэсэн утгаараа ялгаатай, түүнчлэн “тэнгэрт гарах” нь гагцхүү эзэн Чингис хааны нас нөгчихийг цээрлэн хэлсэн гэсэн утгаараа ялгаатай. “Нүгэл мэт бие чину нэхэс одвоос” болон “тул мэт бие чину тулбас одвоос” гэдгийг “одох” үйл үг нь алс хол явах буюу шилжсэн утгаараа “үгүй болох”, “үхэх” -ийг эерүүлэн хэлсэн

²⁸Н.Нансалмаа. Үгийн сан судлал. 2005, х 85

²⁹Н.Нансалмаа. Үгийн сан судлал. 2005, х 60

³⁰Н.Нансалмаа. Үгийн сан судлал. 2005. х. 62

ялгамжтай. “Цагаанд цацваас” болон “хард хахваас” гэдгийн шилжсэн утгаараа (МХИТТ) идсэн уусан зүйл мөгөөрсөн хоолойгоор орж хахан ханиалгах буюу “хахаж үхэх” гэсэн утгаараа мөн “амьгүй болох” үгтэй багтах харьцаанд орж, энэхүү тодотгогч утгаараа ялгаатай байна. Өндөрт гарваас болон хаданд гарваас гэхэд настай хүмүүсийн өөрийн үхлийг эерүүлэн хэлж буй утгаараа ялгаатай. “Урьдасыг үл удаарахуй” гэдгийн “удаарах” үйл үгийн үндсэн утга нь (МХИТТ) дараалах, дэслэх, удаа дараагаар болох гэдгээс өвөг дээдсийг дагах гэсэн шилжсэн утгаар мөн “амьгүй болох, нас барах” гэсэн АБ-АБ давхцалаас гадна, АБ-АБ+В утга буюу тойруулан хэлсэн учир “амьгүй болох” гэсэн утгыг эерүүлсэн ялгаа байна. Мөн “хэр дуусах”, “аминдаа хүртэх” нийлэмж үгүүдэд үхэл нь зүй бусын зуурдын үхэл буюу хорлогдон нас барахыг заасан утгаараа В утга буюу тодотгогч утгаараа ялгаатай байна.

Харин “тэргүүндээ хүртэх болов” болон “хохимой тэргүүндээн хүртэх болов” нь толгойд нь хүрэх (МХИТТ) амь насыг нь хөнөөх буюу толгойд хүрэх гэдгийн алахын нэг хувилбар бөгөөд “хүрэх” үйлд өртөгчийн урвуу харьцаанд алуулах буюу үхүүлэх гэсэн утгыг илэрхийлж байна гэж үзлээ. Түүнчлэн мөнхрүүлэхдүн буюу мөхрүүлэх+дэх нь мөнхрөх үйл үгийн үйлдүүлэх хэв бөгөөд Норжингийн “Монгол хэлний толь”-д үүрдийн болгох гэсэн утгаас нь шилжсэн утгаараа “үхүүлэх” хэмээн алахыг эерүүлэн хэлсэн гэж үзэж байна. Мөн 42 удаагийн давтамж бүхий “үхэх” үйл үг нь үйлийн үйлдэгдэх хэвийн давхар дагаврын хэлбэржилтээр үхүүлдвээс, үхүүлсү, үхүүлэн, үхүүлэх, үхүүлэхүүн, үхүүлэхүй, үл үхүүлэн, үхүүлэв, үхэлдэлцэхүй, үхүүлжүхүй, үхэлдэхүй, үхүүлэн, үхүүлэе, үхүүлдэхүй, үхүүлсэн, үхүүлэгдэх ёс зэргээр орсон байгаа нь “алах”-ыг цээрлэн хэлсэн гэж үзэж, нэг талаасаа Д.Бадамдоржийн (2007) монгол хэлний үгийн сан-утгазүйн ай болох өөрчлөхүйн үйл үгээс үйл үг бүтээх хэвийн нөхцөлийн бүтцийн аргаар урвуу харьцааны илрэл болж байна. Нөгөө талаараа Б.Мөнхцэцэгийн (2012) ойролцоо утгын ангилалын дагуу хуурмаг буюу оновчтой бус ойролцоо үг гэж хэлж болох юм.

Монгол хэлний үгзүйн найруулгын түвшинд үйл үгийн найруулгын үүргийн хүрээнд үйл явдлыг хүчин мөхөсдөх буюу бусдын давамгай хүч чадал, зүй тогтлын эрхэнд болохыг заах тийм нөхцөлд үйлдэгдэх нөхцлөөр хэлбэржүүлн³¹ гэдгээс “үхэх” утгат үгийн утга нь “үхүүлэх” үйлдэгдэх хэвийн хэлбэржилтээрээ гадны нөлөөгөөр “амьгүй болох” гэсэн бас утгын ялгааг илэрхийлж байна. Мөн үгийн утгын эсрэгцлэлээр ойролцоо үгийн багтах харьцаанд орж, АБ-АБ утгаас ялгарах тодотгогч В утгын харьцаагаар хэрэглээгүй талаас яруу утгын ялгааг гаргаж бас болно. Яруу утгын бүрдүүлбэрт Н.Нансалмаа (2005) үгийн утгын хийсвэр хэсэгт багтах хүний болон бусад субъектив хүчин зүйлүүд, өгүүлэгчийн хандлага, хэлэхүйн үйл ажиллагаанд оролцогчдын харилцааны туршлага, нөхцөл, цаг хугацааг илэрхийлдэг хүчлэл, сэтгэл хөдлөл, үнэлэмж, дүрслэл, найруулгын өнгө аяс багтана гэсэнд тулгуурлан “амьгүй болох” утгат ойролцоо үгийг жам ёсоор үхэх, гадны нөлөөлөөр

³¹ Ц.Сүхбаатар. Монгол хэлний найруулгазүй. 2007. х. 230

үхэх гэж ердийн болон цээрлэн хэлсэн гэж зааглаж ердийн утгатай найруулга дундын буюу өндөр найруулгын гэсэн ялгааг тодорхойлж болох юм. Тухайлбал:

“Үхэх”, “үгүй болох”, “зөв эс болсон” гэхэд өнгө аяс, үнэлэмжийн хандлага илэрхийлээгүй, найруулга дундын нэгжүүд байна.

“Хэр дуусах”, “цагаанд цацваас” болон “хард хахваас” гэдэг нь гадны нөлөөгөөр үхсэнийг хэлж байгаа бол, “тэргүүндээ хүртэх болов” болон “хохимой тэргүүндээн хүртэх болов”, “аминдаа хүртэх” гэдэгт мөн зуурдаар үхэх гэсэн дээр өөрийн буруугаас, гэм хийсэн тул сөрөг үнэлэмжтэй гэж ойлгож байна.

Нөгчих, мөнх үгүй, тэнгэрт гарах, нүгэл мэт бие чину нэхэс одвоос болон тул мэт бие чину тулбас одвоос, урьдасыг үл удаарахуй, өндөрт гарваас болон хаданд гарваас зэрэг нь амьгүй болох буюу үхэх утгыг цээрлэн эерүүлэн хэлсэн хүндэтгэлийн өнгө яастай өндөр найруулгын нэгжүүд юм.

Эдгээрийг МНТ-ны Хенишийн орчуулгад хэрхэн буулгасныг хүснэгтээр харуулбал:

	“амьгүй болох” утга бүхий ойролцоо утгат үг, хэллэг	Давтамж	Орчуулга
	Үхэх	42	18 удаа sterben буюу үхэх гэсэн үйл үгээр, 8 удаа орчуулаагүй, 16 удаа töten буюу алах үйл үгээр орчуулсан байна.
	Үгүй болох	8	Starb, starb, nach dem Tode, nach seinem Tode, starb, nach dem Tode ihrer Mutter, nach dem Tode, vernichtet hatte
	нөгчих	1	starb
	Хэр дуусах	1	Wie könnte man aushalten
	Тэргүүндээ хүртэх болов	1	Habe das Unheil über Haupt gebracht
	Хохимойдоо хүртэх болов	1	Habe das Unheil auf Haupt gelenkt
	Аминдаа хүртэх	1	Habe ich mir mein Leben verschertzt und starb
	Өндөрт гарваас	1	Zu den Höhen aufsteigen
	Хаданд гарваас	1	Zu den Felswänden aufsteigen
	Цагаанаа цацваас	1	An den weißen Speisen verschluckt
	Хард хахваас	1	An den schwarzen Speisen erstickt
	мөнхрүүлэхдүн	2	Sollt ihr gleich an Ort und Stelle enthaupten
	Нүгэл мэт бие нэхэс одвоос	2	Dem höhen Baumstamm gleicher Körper sich zum fallen neigt
	Тул мэт бие тулбас одвоос	2	Dem Säulensockel gleicher Körper zum Stutze neigt
	Мөнх үгүй	1	Habe keine ewige Dauer

	Урьдсыг үл удаарах	1	Meine Vorfahren nicht einmal nachfolgen müssen
	Тэнгэрт гарах	2	Stieg zum Himmel auf, nach seinem Aufstieg
	Зөв эс болох ёсон	1	Starb auf der Stelle

Хүснэгт 5. Хенишийн МНТ-ны “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийн орчуулгын дүйцэл

Уран зохиолын орчуулгын тохиргоог Р.Гүрбазар (1996) ерөнхийд нь дөрвөн хувилбараар тогтоосон: а/ бүрэн төгс, б/ үгчилсэн, в/ хялбарчилсан, г/ тайлбарласан. Харин үгийн сангийн түвшинд үгийн тохиргоог бүрэн буюу бүрэн бус оноолт гэснийг бид энд “амьгүй болох” утга бүхий ойролцоо үг, хэллэгийн гагцхүү бүтэц бүрдүүлбэрийн хувьд зөвхөн нэг, хоёр үглэвээрээс бүрдсэн үгийн хүрээнд бүрэн, бүрэн бус оноолт гэсэн дээр нэмж дүйцэлгүй гэсэн 3 дүйцлийн түвшинд харьцуулах нь тохиромжтой гэж үзлээ.

Нийлэмж үг хийгээд өвөрмөц хэлцийн дүйцлийг харин О.Цолмон (2015) болон В.Коллер (1992) нарын уран зохиолын орчуулгын эквивалетийн зарчимд тулгуурлан харгуулав. Эл судалгаанд бид эрдэмтэн судлаач нарын орчуулгын тэнцвэрт чанарыг тохиргоо, оноолт, эквивалет, дүйцэл, дүйцүүлэлт зэрэг олон янзаар нэрлэж буйг “дүйцэл” гэдэг нэр томъёогоор хэрэглэсэн болно. О.Цолмон (2015) уран зохиолын орчуулгын дүйцлийг хэлний 6 үүргээр тодорхойлсон. Үүнд 1. Референтийн функц. Энэ нь “хам сэдэвт” чиглүүлэх үүрэг. 2. Эмотив буюу экспрессив функц нь мэдээллийг илэрхийлэгчийн хандлагыг тодорхойлох үүрэг. 3. Хүсэл зорилгыг илэрхийлэх функц нь мэдээллийг хүлээн авч байгаа хүнд нөлөөлөх үүрэг. 4. Контакт тогтоох функц нь харилцагч хоёр талын хооронд “контакт” бий болсон байдлыг тодорхойлох үүрэг. 5. Мета хэл шинжлэлийн функц нь хэлний тэмдгүүдийн утгыг тодорхойлох үүрэг. 6. Яруу илэрхийллийн функц нь бодол санааг илэрхийлэх илүү “уран сайхны” хэлбэрийг тодорхойлох үүрэг зэргийг багтаасан бол В.Коллер уран зохиолын орчуулгын дүйцлийн 5 загварыг санал болгосон: бодот утгын дүйцэл, нэмэлт буюу шилжсэн утгын дүйцэл, бичвэр буюу эхийн норм хэмжээний дүйцэл, хэрэглээний буюу орчуулж буй хэлний хүлээн авагч руу чиглэсэн дүйцэл, хэлбэр-гоозүйн буюу эхийн зохиогчийн хэв маягийг хадгалахад чиглэсэн дүйцэл. Эдгээр орчуулгын дүйцлийн зарчмуудыг харгалзаж МНТ-д “амьгүй болох” утга бүхий 70 ойролцоо үг, хэллэгийг нэрийн эсрэгцэлийн задаргааны аргаар утгын болоод найруулгын ялгааг тодруулан, тэдгээрийн орчуулгад хэрхэн тусгасан буюу орчуулгын дүйцлийг нягталж дараах ажиглалтыг хийлээ.

I. Нэг болон хоёр үглэвээрээс бүрдсэн “амьгүй болох” утга бүхий үг, хэллэгийн дүйцэл. Үгийн дүйцлийг бүрэн, бүрэн бус, дүйцэлгүй гэсэн түвшинд авч үзлээ.

МНТ-д нийт 42 удаа орсон “үхэх” үйл үгийг Э.Хениш 18 удаа sterben буюу үхэх гэсэн үйл үгээр, 16 удаа töten буюу алах үйл үгээр орчуулсан нь энэ 16 удаа “үхүүлэх” буюу үйлдэгдэх хэвийн хэлбэржилтээр “алах” гэсэн үгийг цээрлэн хэлснийг оновчтой буюу зөв орчуулсан байна. Тиймээс эдгээр 34 удаагийн орчуулга нь бүрэн дүйцэлтэй

байна. Харин 8 удаагийн “үхэх” гэдгийг орчуулаагүй орхисон байгаа бөгөөд шууд утгаар нь дүйцэлгүй гэх нь учир дутагдалтай бөгөөд ер нь “үхэх” үгийн орчуулгын дүйцлийн тусад нь бүлэг болгон нягтлах нь зүйтэй гэж үзлээ.

МНТ-ны I.68-д Есүхэй баатар Татаар иргэдэд хорлогдон үхэхийнхээ өмнө Мэнлигт хандан Тэмүжинг хурдан авчрахыг захиж өгүүлдэг: Хөвүүн минь, Тэмүжинийг үтэрхэн авч ир. Чага минь, Мэнлиг! хэмээгээд нөгчив гэдгийг “Munglik mein Junge, und hole meinen Sohn Temudschin! “So sprach er und starb гэж нөгчих гэсэн хаан цолтой хүний үхлийг цээрлэн хэлснийг sterben буюу үхэх гэсэн үгээр орчуулсан нь эерүүлсэн болон хүндэтгэлийн өнгө аясыг бүрэн дүүрэн гаргаагүй учир бүрэн бус дүйцэл болно.

МНТ-ны II.86-д Сорхон Шарын гэрийн гадаа нэгжүүлүүд унгасан дунд Тэмүжинг хайх зуур: Энэ бас ийм халуунаа (халуунд) унгасан дотор хэр дуусах? хэмээвээс нэгжүүл бууж зорчив гэдгийг “Wie könnte man es schon bei solcher Hitze unter der Wolle aushalten?” гэж хэр дуусах буюу үхэж дуусах гэсэн санааг ташаа ойлгож хэрхэн тэвчиж чадах гэдгээр könnte aushalten гэж орчуулсан нь оновчтой бус буюу бүрэн бус дүйцэл юм.

МНТ-ны IV.140-д Бүри Бөх, Бэлгүдэйтэй барилдаж нуруугаа хугалуулан үхэхдээ

Хаанаас айж,
Аргадан унаж
Арайх (ядах) болон

Аминдаа хүртэв, би хэмээгээд үхэж одов гэдгийг Aus Furcht vor dem Chan habe ich mich absichtlich hinfallen lassen und mich zurückgehalten, und dabei habe ich mir mein Leben verscherzt. So sprach er und starb гэж орчуулсан нь шилжсэн утгаар үхэхийг хэлснийг зөв орчуулсан бөгөөд өөрийн буруугаас гэсэн сөрөг үнэлэмжийг verscherzten³² буюу даажигнах, амьдралаараа тоглох, дэнчин тавих гэсэн утгаараа болон ойролцоо утга нь sich umbringen³³ буюу амиа егүүтгэх тул бүрэн дүйцэл гэж үзэж байна.

МНТ-ны XI.254-д Есүй хатан хааны ач гавъяа, зүтгэлийг нь магтахын зэрэгцээ хааныг насан өндөр болж байгааг Чингис хаанд хандан хэлдэг:

Хаан. Өндөр даваа даван
Өргөн мөрөн гэтлэн
Урт чагуур чагууран

Олон улсаа жившээрэн сэтгэв. Төрсөн эл амьтанд мөнх үгүй ажгуу гэдгийг Aber alle Wesen, die da geboren sind, haben keine ewige Dauer гэж шилжсэн утгаар бүх амьд

³² Deutsch-mongolisch Kompaktwörterbuch. Pons Monsudar. 2008. Герман-монгол толь бичиг.

³³ <https://www.duden.de/rechtschreibung/verscherze>

зүйлс хэзээ нэгэн цагт үхэж, мөнхийн гэж байхгүй гэснийг зөв орчуулсан тул бүрэн дүйцэл болно.

МНТ-ны VIII.199-д: Бидний зарлиг давагсдыг, биднээ танигдах мэтсийг биднээ өгч ирэдхүн. Биднээ үл танигдахун олныг мөн тэнд бөгөөд мөнхрүүлэдхүн гэдгийг Die jenigen, welche unsere Befehle übertreten haben, sollt ihr, soweit sie uns bekannt sind, uns zuschicken. Alle anderen, die uns nicht bekannt sind, sollt ihr gleich an Ort und Stelle enthaupten гэж мөнхрүүлэдхүн гэдгийг sollt an Ort und Stelle enthaupten буюу газар дээр нь толгойг нь авсугай гэж алахыг хэлснийг зөв буулгасан бөгөөд нэн даруй гэсэн ирчимжүүлсэн өнгө яастай байгаа нь бүрэн дүйцэл юм.

МНТ-ны IX.227-д: Мөхрүүлэхүн ёстон бөгөөс бид мөхрүүлье зэ гэдгийг Haben sie die Enthauptung verdient, so werden wir sie enthaupten lassen гэсэн нь мөн алахыг буюу толгойг нь авсугай гэж зөв буулгасан бөгөөд бүрэн дүйцэл болно.

МНТ-ны XII.268-д: ...гахай жил Чингис хаан тэнгэрт гарав гэдгийг Im Schweinejahre 1227 stieg Dschinggis Chan zum Himmel auf гэж Чингис хааны насан өөд болохыг цээрлэн zum Himmel aufsteigen гэж шилжсэн утгаар өвөрмөц хэлцээр тэнгэрт халих гэж хүндэтгэлийн өнгө яастай дээд найруулгаар оновчтой буулгасан тул бүрэн дүйцэл юм. МНТ-ны XII.268-д: Гарсны хойно Есүй хатнаа (хатанд) Тангуд иргэнээс маш их өгөв гэхийг Nach seinem Aufsteigen gab man von dem Tang-ut Volk das Meiste an die Frau Yesui гэж мөн тэнгэрт гарах, тэнгэрт халих гэсэн утгаар орчуулсан нь бүрэн дүйцэл юм.

II. “Амьгүй болох” утга бүхий нийлэж үг болон өвөрмөц хэлцийн орчуулгын дүйцлийг дээр дурдсан дүйцлийн зарчмуудыг харгалзан оновчтой болон оновчгүй дүйцэл гэж харьцуулав.

МНТ-ны III.111-д Хохир муу Чиглэр

Хохимой тэргүүндээн хүртэх болов, би гэдгийг Ich, der gemeine, üble Tschilger, habe das Unheil auf mein verdorrtes Haupt gelenkt гэж буулгасан нь үхэх гэсэн утгыг бүрэн гаргалгүй үхэх аюулд өртөв гэсэн утгаар das Unheil gelenkt гэж үгчилэн орчуулсан нь оновчтой бус дүйцэл болсон.

Мөн Харц муу Чиглэр

Хар тэргүүндээн хүртэх болов гэдгийг Ich, der üble Tschilger niedrigen Standes, habe das Unheil über mein eigenes schwarzes Haupt gebracht гэж мөн үхэх гэсэн утгыг бүрэн гаргалгүй үхэх аюулд өртөв гэсэн утгаар das Unheil gebracht гэж үгчилэн орчуулсан нь оновчтой бус дүйцэл юм.

МНТ-ны V.164-д Хуучдаж (хөгширч)

Хаданд гарваас

Хамаг улсыг

Хэн мэдэх! гэдгийг Ich hier bin jetzt alt geworden. Wenn ich gealtert zu den Höhen aufsteige, bin ich verbraucht гэж орчуулсан нь хөгшин болж насан өөд болох гэсэн утга бус хөгшин болж хэрэггүй болно гэж bin verbraucht гэсэн нь оновчтой бус дүйцэл болно.

МНТ-ны V.167-д Үнэнбээр хан эцэг намайг

Цагаанаа (цагаанд) цацваас

Хард хахваас

Хурчахус Буйруг хан эцгийн чинү зовон, өдий хурааж асан улсыг чину манаа (манд) мэдүүлэхүй? гэдгийг Wer wird aber wirklich, wenn du, sein Vater und König, einmal alt geworden bist, dann dein von deinem Vater Churtschachusbuiruch Chan mit so viel Mühe zusammengebrachte Volk uns zur Regierung geben гэж орчуулсан нь хахаж үхэх буюу насан өөд болох гэсэн утгаар бус нэгэн удаа хөгшин болсон үед гэж einmal alt geworden bist гэсэн оновчтой бус дүйцэл болсон.

МНТ-ны XI.254-д Нэгүл мэт бие чинү

Нэхэс одвоос

Нитгэл мэт улсаа

Хэнээ хэмээмүй гэдгийг Wenn dein dem höhen Baume gleicher Körper sich zum Fallen neigt, wem willst du dann deine Hanfstengeln gleichen Völker unterstellen гэж буулгасан нь хөгширч насан өөд болох гэсэн санааг гаргалгүй гагцхүү хөгширөх буюу бие чинь хөгшрөх үе гэж буулгасан тул оновчтой бус дүйцэл юм.

МНТ-ны XI.254-д Тул мэт бие чинү

Тулбас одвоос

Туял мэт улсаа

Хэнээ хэмээмүй гэдгийг Wenn dein dem Säulensockel gleicher Körper sich zum Sturze neigt, wem willst du dann deine dem Vogelschwarm gleichen Völker anvertrauen гэж буулгасан нь хөгширч насан өөд болж одох гэсэн санааг гаргалгүй гагцхүү хөгширөх буюу бие чинь хөгшрөх үе гэж буулгасан тул оновчтой бус дүйцэл болно.

МНТ-ны XI.254-д Урьдасыг үл удаарахуйгаас

Умартаж ажгуу гэдгийг Auch ich selbts habe vergessen, daran zu denken, als ob ich meinen Vorfahren nicht einmal nachfolgen müsste гэж орчуулсан нь өвөг дээдсийг дагах гэсэн шилжсэн утгаар мөн “амьгүй болох, нас барах” утгаар nachfolgen müsste гэсэн нь оновчтой дүйцэл юм.

МНТ-ны XII.272-д Аливаа үгээ өгүүллээ, би. Согтов хэмээгээд гарч одож, зөв эс болсон ёсон тийм гэдгийг Nachdem er so gesprochen hat, gign er hinaus und starb auf der Stelle гэж орчуулсан нь нас барах гэсэн утгыг өнгө аяс, үнэлэмжийн хандлага илэрхийлээгүй илтгэж байгаа учир оновчтой дүйцэл болно.

Дүгнэлт

Ойролцоо утгын давтамж болон орчуулгын олон хувилбартай байгаа “үхэх”, “үгүй болох” үг, хэллэгийг тусад нь дэлгэрэнгүй харьцуулж, нягтлах нь зүйтэй гэж үзлээ. Үлдсэн 16 “амьгүй болох” утга бүхий үг, хэллэгийн дүйцэлийг хоёр бүлэг

болгон харьцуулж, эхний хэсэгт нэг болон хоёр үглэвэрээс бүрдсэн 8 үг, хэллэгийн дүйцлийг бүрэн, бүрэн бус болон дүйцэлгүй гэсэн дүйцлийн 3 түвшинд харьцуулахад “нөгчих” болон “хэр дуусах” үг, хэллэгийн орчуулгын дүйцэл нь бүрэн бус бусад хөрвүүлэг нь бүрэн дүйцэлтэй байна. Огт дүйцэлгүй үг, хэллэг байсангүй. Харин дараах хэсэгт нь “амьгүй болох” утга бүхий 8 нийлэмж үг, өвөрмөц хэлцийн орчуулгыг оновчтой болон оновчтой бус гэсэн ангиллаар харьцуулахад “урьдасыг үл удаарах” болон “зөв эс болсон ёсон” үг хэллэгийн орчуулга л оновчтой болсон бөгөөд бусад нь оновчгүй орчуулгын дүйцэл байна. Тиймээс МНТ-ны “амьгүй болох” утга бүхий үг, хэллэгийн цээрэлсэн, эерүүлсэн өнгө аяс, утга найруулгын ялгаа герман хэлэнд бүрэн төгс буусангүй. Гэхдээ уран зохиолын орчуулгад энэ нь төрөл бус хэлэнд тохиолддог нийтлэг үзэгдэл юм.

Abstract

We aimed to illustrate the equivalence of the words with similar meaning in the German translation of the Secret History of the Mongols by Henisch. For this purpose, the meaning “to loose life” was examined in relation to synonyms and similar expressions, and, hence, how these variations were reflected in the translation.

Номзүй:

- Ш.Чоймаа. Монголын нууц товчоо. Эртний үг, хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. 2011. УБ.
- Э.Хениш. Монголын нууц товчоо. Герман орчуулга. 1948. Лайпциг хот.
- Д.Бадамдорж. Монгол хэлний утгасудлал. 2001. УБ.
- Д.Бадамдорж. Монгол хэлний утгазүйн шинжилгээ. 2007.УБ.
- Б.Баярмэнд. Нууц товчооны ертөнц. Орчуулга. Ш.Озова.1980. УБ.
- Н.Нансалмаа. Үгийн сан судлал. 2005.УБ.
- Б.Мөнгөнцэцэг. Монгол хэлний ойролцоо үг, түүний утгын ангилал. Монгол хэлний ойролцоо зэргэд. 2012. УБ.
- Б.Одгэрэл. Монгол хэлний “хүний амь тасрах” гэсэн утга бүхий үг, хэллэгийн утга найруулгын онцлог. 2010. УБ.
- Д.Отгонсүрэн. Ойролцоо утгат үгийн найруулгын үүрэг: Монгол хэлний үгийн сангийн найруулга зүй.1998. УБ.
- А.Пунсаг. Монголын нууц товчоо дах ёс, заншлын судалгаа. 2010. УБ.
- Ш.Чоймаа, Д.Заяабаатар. Академич Ц.Дамдинсрэнгийн “МНТ”-ы орчуулгын онцлог. МНТ. 2011.УБ.
- Ц.Өлзийхутаг. Монгол хэлний үгийн сангийн судлал. 1979. УБ.
- С.Энхжаргал. Монгол хэлний ойролцоо утгат үйл үгийн тухай. 2007. УБ.
- Монгол хэлний их тайлбар толь.
- Монгол хэлний толь.
- Werner Koller: Einführung in die Übersetzungswissenschaft. 4. völlig neu bearbeitete Auflage. Quelle & Meyer, Heidelberg/Wiesbaden 1992